



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 108

Хараат

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тус сумын Дэлгэрэхзам багийн нутаг “Улаан худаг” гэдэг газарт өвөлжиж байгаа малчин Л.Уртнасангийн суурьт малын гоц халдварт бог малын Мялзан өвчин илэрсэн тул 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Голомтын хүрээ координат, цэгийг тогтоож ажиллахыг үүрэг болгосугай.

3.Хязгаарлалтын бүсэд байгаа малд шинжилгээ, үзлэг тандалт, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч П.Бурмаад үүрэг болгосугай.

4.Малчид иргэд олон нийтэд малын гоц халдварт бог малын Мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарын авлаг, мэдээ мэдээллийг цахимаар олон нийтэд хүргэх, голомт сэжигтэй бүс нутгийн малчдад малын хариуллага маллагаатай байлгаж, хорио цээрийн дэглэмийн журмыг мөрдөж ажиллах талаар мэдээл өгөхийг МЭТасгийн дарга Т.Өлзийбат, БЗДарга нарт үүрэг болгосугай.

5.Дээрх үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн зардлын тооцоог гаргахыг ЗДТГазрын санхүү албаны дарга Б.Цэндмаа, нябо Ж.Чулуунтогтох нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН



4823000045